


ЗУРГАА. САНХҮҮ, БҮРТГЭЛ

6.1 САНХҮҮ, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН АЛБА

Санхүү нягтлан бодох бүртгэлийн албаны бүтэц зохион байгуулалт, санхүүгийн албаны ажиллагчдын ажлын байрны тодорхойлолт, нягтлан бодох бүртгэлийн ерөнхий бодлого, бүртгэлийн техник хэсэг, өртөг тооцох аргачлал, холбогдох дүрэм журмыг ШУТИС-ийн захирлын 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/237 тоот “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн батлах тухай” захирлын тушаалаар батлан мөрдөн ажиллаж байна. Захирлын тушаалаар уг албанд албаны дарга бөгөөд төвлөрсөн сан хариуцсан ахлах нягтлан бодогч, захиргаа хариуцсан ахлах нягтлан бодогч, эрдэм шинжилгээ хариуцсан ахлах нягтлан бодогч, санхүүгийн бодлого, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн, сургалтын зээл, санхүүжилт хариуцсан мэргэжилтэн, бүртгэл тооцооны ажилтан, өр барагдуулах ажилтан гэсэн 7 орон тоотой боловч 6 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явууллаа.



Зураг 1. ШУТИС-ийн Санхүү нягтлан бодох бүртгэлийн албаны бүтэц

Санхүү нягтлан бодох бүртгэлийн алба нь НББОУС, УСНББОУС, Дээд боловсролын тухай, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Шилэн дансны тухай, Татварын ерөнхий хуулиуд, тэдгээрт нийцүүлэн гаргасан Улсын их хурал, Засгийн газар, холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудын тушаал, тогтоолын дагуу үйл ажиллагаагаа төлөвлөж, зохион байгуулдаг. Мөн Монгол улсын хууль, олон улсын стандарт, төрийн захиргааны байгууллагуудын тушаал, тогтоолуудад нийцүүлэн боловсролын байгууллагын онцлогыг харгалзсан санхүү, бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой батлагдсан өөрсдийн 40 гаруй дүрэм журам, тушаалыг мөрдөн ажиллаа.

ШУТИС-ийн хэмжээнд тайлант хугацаанд 2024 үндсэн орон тоотой ажилласнаас гүйцэтгэх ажилтан 1221, үйлчилгээний ажилтан 406, гэрээт болон цагийн багш 391 хүн байна. 2022 оны 04 дүгээр сарын 8-ны байдлаар нийт оюутны тоо идэвхтэй сурч буй сонголт хийсэн 15,761 оюутан суралцагчид суралцаж байна. Санхүү нягтлан бодох бүртгэлийн албаны хувьд албаны дарга, ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн, бүрэлдэхүүн нэгжүүдийн ахлах нягтлан бодогч, тооцооны нягтлан бодогч, нярав зэрэг нийт 50 гаруй орон тоотой ажилласан.

Санхүү нягтлан бодох бүртгэлийн албаны зорилго нь: ШУТИС-ийн дунд болон богино хугацааны төлөвлөгөөний зорилго, зорилтууд, захирлын үр дүнгийн гэрээг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд төсөв боловсруулахад санал өгөх, батлагдсан төсвийн дагуу зарцуулалт хийх, төсвийн зарцуулалтыг үнэн зөв бүртгэх, санхүүгийн тайлан гаргах, тайланд шинэжилгээ хийх, төсвийн зарцуулалтанд хяналт тавих, нягтлан бодох бүртгэлийн удирдлага, зохион байгуулалтыг хэрэгжүүлэх, эрх зүйн орчинг сайжруулах

Санхүү нягтлан бодох бүртгэлийн албаны чиг үүрэг:

- ШУТИС-ийн захирлын болон бүрэлдэхүүн нэгжүүдийн захирлын үр дүнгийн гэрээнд тулгуурлан санхүүгийн орлого, зарлага, худалдан авах ажиллагааны төсөв, төлөвлөгөөг нэгтгэн батлуулахад санал өгөх
- ШУТИС-ийн бүрэлдэхүүн нэгжүүдийн орлого, зарлагын жилийн төсөв, төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, Хөгжлийн хөтөлбөр төлөвлөлтийн газартай хамтран ажиллах
- Бүрэлдэхүүн нэгж, төвийн төсвийн зарчмыг хэрэгжүүлэхэд санхүүгийн үйл ажиллагааг НББОУС-ын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв бүртгэл хөтлөх
- НББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу аккрузал сууриар нягтлан бодох бүртгэлийг хөтлөх
- ШУТИС-ийн 2021 он хүртэлх стратегийн төлөвлөгөө, замын зураглал, БСШУСЯ-ны их дээд сургуулийн шинэчлэлийн бодлогын хүрээнд тус сургуулийн олон улсын болон дотоодын ЭШ-ний төсөл, гэрээт ажлын төсвийн төслийг хянах, төсвийн гүйцэтгэлд хяналт тавих, төслийн өмч хөрөнгийг бүртгэх, хадгалах, ашиглалтанд хяналт тавих
- Бүрэлдэхүүн нэгж, төвийн мөнгөн хөрөнгийн бүртгэл тооцоо, хадгалалт, гүйлгээний мэдээлэл солилцоо, зээлийн болон бусад бүтээгдэхүүн үйлчилгээний хүрээнд арилжааны банкуудтай хамтын ажиллагааны гэрээ боловсруулах, дүгнэх
- Бүрэлдэхүүн нэгж, төвийн бараа материал, үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой төрийн өмчийн бодлогыг хэрэгжүүлэх, бүртгэх, тооллого хийх, хадгалалт, хамгаалалтанд хяналт тавих, Өмч хамгаалах комисс, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар ашиглалтгүй актлах хөрөнгийг танилцуулах, шийдвэрлүүлэх
- ШУТИС-ийн бүрэлдэхүүн нэгжүүдийн хөрөнгийн бүртгэл, ашиглалт, тооллого, хадгалалт, хамгаалалттай хамааралтайгаар Хөрөнгө оруулалт хангамжын газартай хамтран ажиллах
- Бүрэлдэхүүн нэгж, төвийн өглөг, авлагын төлбөр тооцоог бүртгэх, хянах, өр төлбөр, авлагыг бууруулах, найдваргүй авлага, өр төлбөрийг Удирдах зөвлөлд танилцуулах, шийдвэрлүүлэх
- Төсвийн хөрөнгийн үр ашигтай зарцуулалт, удирдлагын шийдвэр ил тод, нээлттэй, олон нийтийн хяналттай байх зарчмын хүрээнд Шилэн дансны тухай хуулийн дагуу төсөв, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг цаг хугацаанд нь цахим хуудсанд байршуулах
- Бүрэлдэхүүн нэгжийн төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ШУТИС-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу холбогдох дансанд бүртгэх, тайлагнах
- УСНББОУС, СТОУС, Сангийн сайдын төсөвт байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх зааврын дагуу санхүүгийн тайлан боловсруулах, тайлагнах
- Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэгдсэн санхүүгийн тайланд нэгтгэх
- Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нягтлан бодох бүртгэл, тайлагналын мэдээллийн нэгдсэн санд төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүгийн тайлан мэдээг мэдээлэх
- Бүрэлдэхүүн нэгж, төвийн мөнгөн хөрөнгө, бараа материал, өмч хөрөнгө, орлого, зарлага, төсөв, төсвийн гүйцэтгэл зэрэг нягтлан бодох бүртгэлийн мэдээ, мэдээллийг удирдлагад хүргүүлэх, удирдлагыг мэдээллээр хангах

- Бүх шатны бүрэлдэхүүн нэгжийн төсвийн гүйцэтгэл, нягтлан бодох бүртгэл, хөтлөлт, санхүүгийн тайлагналыг санхүүгийн бүртгэлийн нэгдсэн мэдээллийн сүлжээгээр хангах, мэдээллийн санг бүрдүүлэх, санхүү нягтлан бодох бүртгэлийн цахим системийг хөгжүүлэх
- Бүрэлдэхүүн нэгжүүдийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн мэдээллийн нэгдсэн системийн мэдээлэл нь холбогдох шийдвэр, эрх зүйн акт, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтаар баталгаажуулсан эсэхийг хянах, зөвлөх
- Бүрэлдэхүүн нэгж, төвийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах, нэгжүүдийн санхүүгийн тайлагналын хүрээнд санхүүгийн үр дүнг тодорхойлж төсөв, төсвийн гүйцэтгэл, орлого, зарлагын төрлүүдээр санхүүгийн шинжилгээ хийн цаашид анхаарах, зөвлөмж гаргах, санхүүгийн үр дүнг хэлэлцүүлэх, үр дүнгийн нэмэгдэл тооцох
- Бүрэлдэхүүн нэгжийн үйл ажиллагааны онцлог, салбарын нөхцөл байдлаас хамаарч НББОУС, хууль, дүрэмд нийцүүлэн бүрэлдэхүүн нэгжийн мөрдөх санхүү, нягтлан бодох бүртгэлийн дүрэм, журмыг боловсруулах, батлуулах
- Бүрэлдэхүүн нэгжийн төсвийн зарцуулалт, тайлагнал, нягтлан бодох бүртгэл хөтлөлтөнд хяналт тавих
- Аудитын тухай хуулийн дагуу хөндлөнгийн болон Үндэсний аудитын газар, Нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газар, Татварын ерөнхий хуулийн дагуу Татварын ерөнхий газар, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу Сангийн Яамны, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар зэрэг төрийн захиргааны болон хяналтын байгууллагуудын хяналт, шалгалтанд хамрагдах, санхүү бүртгэлийн үйл ажиллагаагаа хянан баталгаажуулах
- Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн байгууллага, төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгжийн нягтлан бодогчдод тавигдах шаардлагад үндэслэсэн бүрэлдэхүүн нэгжийн ахлах нягтлан бодогчийн албан тушаалд тавигдах шаардлага, шалгуурыг тодорхойлох, мөрдөх
- Бүрэлдэхүүн нэгжийн ахлах нягтлан бодогч, тооцооны нягтлан бодогч, нярав, бүртгэлийн албаны ахлах нягтлан бодогч, ажиллагчдыг харьяалагдах бүрэлдэхүүн нэгжийн захирал, Санхүү хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал, Захиргаа, хүний нөөцийн газартай зөвшилцөн томилж, чөлөөлөхөд санал өгөх
- ШУТИС-ийн бүрэлдэхүүн нэгжүүдийн сургалтын төлбөрийн бүртгэл хөтлөлт, төлөлтөнд хяналт тавих, сургалтын авлага, өр төлбөрийг барагдуулах чиглэлээр ажлын төлөвлөгөө боловсруулан Сургалтын бодлого зохицуулалтын газартай хамтран ажиллах, ажлын тайлан бичих
- ШУТИС-ийн бүрэлдэхүүн нэгжүүдийн сургалтын бус авлага, өр төлбөр барагдуулах чиглэлээр ажлын төлөвлөгөө боловсруулан Дотоод хяналтын албатай хамтран ажиллах, ажлын тайлан бичих, шүүх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар байгууллагыг төлөөлөн оролцох
- Бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн нягтлан бодогч, нярав, санхүүгийн ажилтнуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, сургалтанд хамруулах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Албаны хувьд 2021 онд санхүүгийн нягтлан бодох бүртгэлийн программд нэмэлт өөрчлөлтийг оруулж, санхүүгийн дүрэм, журмыг хэрэгжүүлэх, Захирлын зөвлөлийн хурлаар батлагдсан шийдвэрийг хэрэгжүүлэх, санхүүгийн ажилтнуудын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, сургалтын чанар, хүртээмжийг сайжруулах, гадаад харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, санхүү, хөрөнгө оруулалт, үйлчилгээний ажлын чанарыг дээшлүүлэх, үр дүнг нэмэгдүүлэхэд анхааран ажиллаа. 2021 онд ШУТИС-ийн бүрэлдэхүүний 11 сургууль, 2 ахлах сургууль, Коосен ТКоллеж, Захиргаа, Эрдэм шинжилгээ инновацийн газар, Ой мод сургалт судалгааны хүрээлэн, Хэвлэлийн газар, Шинжлэх ухаа технологийн номын сан зэрэг нийт 20 нэгжүүд үйл ажиллагаа явуулж тайлан баланс гаргасан. Монгол улсын Сангийн сайдын 388 тоот санхүүгийн тайлан, тодруулга, 55 тоот эдийн засгийн ангилал болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн Санхүүгийн байдлын тайлан (СТ-1А), үр дүнгийн тайлан (СТ-2А), мөнгөн гүйлгээний тайлан (СТ-3А), цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (СТ-4А), санхүүгийн тайлангийн тодруулга (ТБСТТ-1-12) зэргийг гарган өгч, ШУТИС-ийн удирдлагын нэгдсэн системийн дэд хэсэг болох УСНББОУС-д нийцсэн санхүүгийн мэдээллийг боловсруулах “И-Finance” санхүүгийн программаар санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан. 2021 оны санхүүгийн хагас жилийн тайланд Үндэсний аудитын газар, “Амгалан ахуй аудит” аудитын компанийн санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийгдсэн.

6.2 САНХҮҮГИЙН ТАЙЛАН БАЛАНС

ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 15 тоот тогтоолын дагуу Дархан-Уул аймаг дахь Технологийн сургуулийн харьяа Ерөнхий боловсролын Ахлах сургуулийн хөрөнгө, өр төлбөрийг Технологийн сургуулийн балансаас балансад шилжүүлж, эхлэлтийн санхүүгийн тайлан гаргасан.

ШУТИС-ийн Санхүүгийн тайлан баланс/мян. төг/

Хүснэгт 1.

Балансын үзүүлэлт	2020 оны IY улирал	2021 оны IY улирал	Өсөлт +, бууралт -	
			Дүн	Хувь
Мөнгөн хөрөнгө	23,762,109.5	24,785,114.9	1,023,005.4	4.3
Авлага	4,207,928.0	3,834,920.5	(373,007.5)	8.9
Үүнээс: 1. Сургалтын төлбөрийн авлага	2,854,223.8	2,906,600.0	52,376.2	1.8
Урьдчилгаа	752,524.7	776,524.7	24,000.0	3.2
Бараа материал	1,907,884.5	2,217,490.9	309,606.4	16.2
Үндсэн хөрөнгө	107,916,325.6	121,219,376.7	13,303,051.1	12.3
Нийт хөрөнгийн дүн	138,546,772.3	152,833,427.7	14,286,655.4	10.3
Өр төлбөр	9,499,640.8	10,220,566.3	720,925.5	7.6
Үүнээс: 1. Урьдчилж орсон орлого	8,815,185.5	9,275,647.2	460,461.7	5.2
2. Урт хугацаат өр төлбөр	57,158.0	52,187.7	(4,970.3)	8.7
Засгийн газрын хувь оролцоо	30,341,483.2	30,567,495.6	226,012.4	0.7
Хуримтлагдсан үр дүн	37,597,377.7	50,939,036.2	13,341,658.5	35.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	61,108,270.6	61,106,329.6	(1,941.0)	0.0
Өр төлбөр, эзний өмчийн дүн	138,546,772.3	152,833,427.7	14,286,655.4	10.3

Тайлант хугацаанд БШУЯамнаас цахим төгсөлтийн арга хэмжээний санхүүжилтэнд 20,000.0, ХНХЯамнаас МехТС, ҮТС-ийн ОМССХүрээлэнгийн мэргэжлийн анхан шатны сургалтанд 460,642.3, орон нутгийн төсвөөс ДаТС-ийн Ахлах сургууль, ШУТАхлах сургуулийн сургалтанд 128,376.4, Инженер, техникийн дээд боловсрол төслөөс 50,000.0, ШУТСангаас 705,197.3, БЗС-аас буцалтгүй тусламжийн санхүүжилт 1,690,603.0, Засгийн газар хоорондын гэрээгээр суралцагч гадаад оюутны сургалтын төлбөр, тэтгэлгийн 6,284.4, оюутны хөгжлийн зээлийн 1,220,645.9, Ерөнхийлөгчийн нэрэмжит оюутны тэтгэлгийн 440,004.8 мянган төгрөгийн санхүүжилт тус тус хийгдсэн.

“Нийгмийн даатгалаас чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай” хуулийн дагуу 2021 оны 1-6 сарын ажил олгогчийн төлөх 531,980,631.79 төгрөгийн чөлөөлөгдсөн нийгмийн даатгалын шимтгэлийн дүнгээр Засгийн газрын хөнгөлөлт дансанд бүртгэж, санхүүгийн тайланд тусгалаа.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд 4 банкны нийт 60 дансны үлдэгдэл хамрагдсан бөгөөд өмнөх оны мөн үеэс 4.3 хувиар өссөн байна. 2021 оны 12-р сарын 31-ний байдлаар нийт 81,521.88 ам.долларын үлдэгдэлтэй байсан ба Монгол банкны 2021 оны 12-р сарын 30-ны өдрийн хаалтын ханш 2,848.80 төгрөгөөр ханшийн тэгшитгэл хийж төгрөгт хөрвүүлж тайланд тусгасан.

Нийт авлага 3,834,920.5 мянган төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 373,007.5 мянган төгрөгөөр буюу 8.9 хувиар буурсан.

Авлагын 2,906,600.0 мянган төгрөг буюу 75.8 хувь нь оюутнуудаас авах сургалтын төлбөрийн дутуу, СТС-ийн суутгал, байгууллага, хувь хүнээс авах авлага 24.2 хувийг эзэлж байна.

Захирлын 2021 оны 01-р сарын 29-ний өдрийн А/16, 06-р сарын 18-ны өдрийн А/108, 12-р сарын 24-ний өдрийн А/245 тоот тушаалаар бүрэлдэхүүн сургууль, нэгж хооронд 1,092,081,365.57 төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлэн, данс бүртгэлд бүртгэж, тайланд тусгалаа.


Тайлант хугацаанд гадаад, дотоодын байгууллага, хувь хүн, төслийн хөрөнгөөр бий болсон 11,258,921.2 мянган төгрөгийн хандивын үндсэн хөрөнгийг бүртгэсэн.

ШУТИС-ийн Бүрэлдэхүүн нэгжүүдийн орлогын төсөв, гүйцэтгэл /төгрөгөөр/
Хүснэгт 2.

№	Бүрэлдэхүүн нэгжүүд	Орлого төсөв	Гүйцэтгэл орлого	хувь
1	Барилга, Архитектурын сургууль	6,387,680,500	6,743,321,543	105.57%
2	Бизнесийн удирдлага, Хүмүүнлэгийн сургууль	3,326,651,200	3,421,592,341	102.85%
3	Бизнесийн ахисан түвшний сургууль	2,040,471,500	2,308,502,206	113.14%
4	Геологи, Уул уурхайн сургууль	4,226,300,700	4,568,238,949	108.09%
5	Гадаад хэлний сургууль	532,459,360	516,224,020	96.95%
6	Дархан-Уул аймаг дахь технологийн сургууль	2,392,399,500	2,840,197,282	118.72%
7	Механик, Тээврийн сургууль	3,803,804,410	4,169,167,429	109.61%
8	Мэдээлэл, Холбооны технологийн сургууль	6,121,581,300	5,958,859,677	97.34%
9	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	1,110,727,200	933,772,168	84.07%
10	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	3,778,906,200	3,565,382,282	94.35%
11	Эрчим хүчний сургууль	6,250,575,600	6,191,380,059	99.05%
12	ШУТИС Нээлттэй боловсролын төв	50,052,800	60,592,638	121.06%
13	ШУТИС Коосен технологийн сургууль	570,000,000	667,478,000	117.10%
14	ШУТИС Ахлах сургууль	504,000,000	602,727,500	119.59%
15	Дархан-Уул аймаг Ахлах сургууль	143,000,000	181,949,688	127.24%
16	Эрдэм шинжилгээ инновацийн газар	365,000,000	435,288,570	119.26%
17	ШУТИС Төв номын сан	-	13,516,844	#DIV/0!
18	ШУТИС Хэвлэлийн газар	549,390,000	395,562,014	72.00%
19	ШУТИС Захиргаа	100,000,000	93,279,258	93.28%
20	ШУТИС Ой модны сургалт судалгааны төв	434,000,000	139,632,379	32.17%

ТӨБЗГ-ын 2021 оны 11-р сарын 11-ний өдрийн 503 тоот тогтоолын дагуу анхны өртгөөрөө элэгдлээ нөхсөн 8441 нэрийн 17,256,402,395.78 төгрөгийн үнэ бүхий 20463 ширхэг хөрөнгийн ашиглалтын хугацааг сунган 7,721,032,600.48 төгрөгөөр үнийг шинэчлэн тогтоохоос актлагдсан болон 2020 онд худалдан авсан хөрөнгийг хасч тооцсноор 17,232,802,863.16 төгрөгийн үнэ бүхий 20363 ширхэг хөрөнгийн ашиглалтын хугацааг сунган, 7,708,244,792.74 төгрөгөөр үнийг шинэчлэн тогтоож санхүүгийн тайланд тусгасан.

2021 онд ШУТИС-ийн бүрэлдэхүүн нэгжүүдээс ГХС, МХТС, ХШУС, ҮТС, ЭХС, Хэвлэх газар, Захиргаа, ОМССХүрээлэн орлогын төсөв биелэгдээгүй тасарсан байна.



Зураг 2. ШУТИС-ийн бүрэлдэхүүн нэгжүүдийн орлогын гүйцэтгэл

ТӨБЗГ-ын 2021 оны 06-р сарын 04-ны өдрийн А-1/919 албан тоот, 06-р сарын 15-ны өдрийн 216 тоот тогтоолын дагуу 983,191,027.17 төгрөгийн үндсэн хөрөнгө актлахаас үлдэгдэл өртөгтэй 382,993.60 төгрөгийн хөрөнгийг хасаж тооцсноор 982,808,033.57 төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасч, санхүүгийн тайланд тусгасан.

2021 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн ШУТИС, Санхүү эрхэлсэн дэд захирлын 5/100 тоот албан бичгийн хүрээнд дараах зардал, зарцуулалтыг зогсоон, бууруулан ажилласан.

- Зогсоосон зардал: шагнал урамшуулалын зардал, зочин төлөөлөгч хүлээн авах зардал, гадаад мэргэжилтний зардал, гадаад томилолтын зардал, багшийг дэмжих зардал, мэргэжил дээшлүүлэх зардал, ойн арга хэмжээний зардал, багш ажилтны арга хэмжээний зардал, оюутны үйлчилгээний зардал
- Бууруулсан зардал: Нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардал, дотоод албан томилолтын зардал, мэдээлэл сурталчилгааны зардал, сургалтын бичиг хэргийн зардал, захиргааны бичиг хэргийн зардал
- Хэмнэсэн зардал: Гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир усны зардал


ШУТИС-ийн Бүрэлдэхүүн нэгжүүдийн зарлагын төсөв, гүйцэтгэл /төгрөгөөр/
Хүснэгт 3.

№	Бүрэлдэхүүн нэгжүүд	Зарлага төсөв	Гүйцэтгэл зарлага	хувь
1	Барилга, Архитектурын сургууль	5,666,339,400	4,731,372,395	83.50%
2	Бизнесийн удирдлага, Хүмүүнлэгийн сургууль	3,999,364,100	3,641,795,722	91.06%
3	Бизнесийн ахисан түвшний сургууль	1,086,996,300	878,917,380	80.86%
4	Геологи, Уул уурхайн сургууль	5,657,251,900	5,016,735,333	88.68%
5	Гадаад хэлний сургууль	2,735,622,400	2,373,325,771	86.76%
6	Дархан-Уул аймаг дахь технологийн сургууль	3,344,533,800	2,833,496,883	84.72%
7	Механик, Тээврийн сургууль	5,214,861,400	4,242,116,078	81.35%

8	Мэдээлэл, Холбооны технологийн сургууль	4,868,418,100	4,104,278,886	84.30%
9	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	4,244,580,800	3,676,598,102	86.62%
10	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	5,472,280,900	3,756,561,187	68.65%
11	Эрчим хүчний сургууль	4,384,436,700	3,536,789,185	80.67%
12	ШУТИС Нээлттэй боловсролын төв	835,753,600	546,648,248	65.41%
13	ШУТИС Коосен технологийн сургууль	694,221,600	497,473,467	71.66%
14	ШУТИС Ахлах сургууль	846,845,160	522,937,355	61.75%
15	Дархан-Уул аймаг Ахлах сургууль	233,853,650	209,275,487	89.49%
16	Эрдэм шинжилгээ инновацийн газар	467,740,000	363,344,607	77.68%
17	ШУТИС Төв номын сан	906,811,400	734,065,388	80.95%
18	ШУТИС Хэвлэлийн газар	472,183,800	341,033,230	72.22%
19	ШУТИС Захиргаа	7,842,343,000	6,727,195,369	85.78%
20	ШУТИС Ой модны сургалт судалгааны төв	546,321,200	244,114,497	44.68%

Тайлант хугацааны эцэст байгууллага, хүмүүст 892,731.4 мянган төгрөгийн өглөгийн, 9,275,647.2 мянган төгрөгийн урьдчилж орсон орлого (сургалтын болон оюутны байрны төлбөр, бусад төлбөр, төсөл, гэрээт ажлын)-ын үлдэгдэлтэй байна.

Урт хугацаат зээлийн 52,187.7 мянган төгрөгийн өглөг нь Төрийн өмчийн хорооны 2011 оны 11-р сарын 11-ний өдрийн тоот тогтоолын дагуу УБ Дулааны Сүлжээ ТӨХК-аас балансаас балансад шилжүүлэн бүртгэж авсан Халаалтын цогц төхөөрөмжийн үлдэгдэл төлбөр бөгөөд 2032 онд төлөгдөж дуусах гэрээтэй болно.



Зураг 3. ШУТИС-ийн бүрэлдэхүүн нэгжүүдийн зарлагын гүйцэтгэл

2021 онд МУЗГ-ын 43 тоот тогтоол, ШУТИС-ийн санхүү эрхэлсэн дэд захирлын 5/100 тоот албан бичгийн хүрээнд ШУТИС-ийн бүрэлдэхүүн нэгжүүдийн зардлыг зогсоон ажилласан. Тиймээс зардал хэтэрсэн бүрэлдэхүүн нэгжүүд байхгүй байна.

Өмнөх үеийн үр дүнг үндсэн хөрөнгө, авлага, өглөг, урьдчилгааны залруулга, акталсан үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний хэрэгжсэн дүн зэргээр нийт 40,309,856.79 төгрөгөөр нэмэгдүүлж, авлага,

элэгдэл, урьдчилж орсон орлогын залруулга зэргээр нийт 55,531,880.00 төгрөгөөр бууруулан бичилт хийсэн.

Мөн бүрэлдэхүүн сургууль, нэгжийн хооронд хөрөнгө, өр төлбөр шилжүүлсэнтэй холбоотой 66,491,495.00 төгрөгийн нэмэгдсэн, хасагдсан бичилтүүд хийгдсэн болно.

ШУТИС-ийн Бүрэлдэхүүн нэгжүүдийн үр дүн /төгрөгөөр/

Хүснэгт 4.

№	Бүрэлдэхүүн нэгжүүд	Орлогын гүйцэтгэл	Зарлага гүйцэтгэл	Үр дүн
1	Барилга, Архитектурын сургууль	6,743,321,543	4,731,372,395	2,011,949,148
2	Бизнесийн удирдлага, Хүмүүнлэгийн сургууль	3,421,592,341	3,641,795,722	- 220,203,381
3	Бизнесийн ахисан түвшний сургууль	2,308,502,206	878,917,380	1,429,584,826
4	Геологи, Уул уурхайн сургууль	4,568,238,949	5,016,735,333	- 448,496,384
5	Гадаад хэлний сургууль	516,224,020	2,373,325,771	- 1,857,101,752
6	Дархан-Уул аймаг дахь технологийн сургууль	2,840,197,282	2,833,496,883	6,700,398
7	Механик, Тээврийн сургууль	4,169,167,429	4,242,116,078	- 72,948,649
8	Мэдээлэл, Холбооны технологийн сургууль	5,958,859,677	4,104,278,886	1,854,580,792
9	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	933,772,168	3,676,598,102	- 2,742,825,934
10	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	3,565,382,282	3,756,561,187	- 191,178,905
11	Эрчим хүчний сургууль	6,191,380,059	3,536,789,185	2,654,590,875
12	ШУТИС Нээлттэй боловсролын төв	60,592,638	546,648,248	- 486,055,611
13	ШУТИС Коосен технологийн сургууль	667,478,000	497,473,467	170,004,533
14	ШУТИС Ахлах сургууль	602,727,500	522,937,355	79,790,145
15	Дархан-Уул аймаг Ахлах сургууль	181,949,688	209,275,487	- 27,325,799
16	Эрдэм шинжилгээ инновацийн газар	435,288,570	363,344,607	71,943,962
17	ШУТИС Төв номын сан	13,516,844	734,065,388	- 720,548,544
18	ШУТИС Хэвлэлийн газар	395,562,014	341,033,230	54,528,784
19	ШУТИС Захиргаа	93,279,258	6,727,195,369	- 6,633,916,111
20	ШУТИС Ой модны сургалт судалгааны төв	139,632,379	244,114,497	- 104,482,118

2021 онд ШУТИС-ийн бүрэлдэхүүн нэгжүүдээс БУХС, ГУУС, ГХС, МеТС, ХШУС, ҮТС, НБТ, ДаАС, Номын сан, Захиргаа, ОМССХүрээлэн хасах үр дүнтэй гарсан байна.

Сургууль хоорондын тооцооны орлого, зардал, өглөг, авлагыг бүрэлдэхүүн сургууль, нэгж тус бүрийн санхүүгийн тайланд тусгав.

Сургууль хоорондын тооцооны дараах гүйлгээг устгах бичилт хийж, нэгтгэсэн тайланг гаргалаа. Үүнд:

1. Авлага, өглөгийн эхний үлдэгдэл 243,298,324.07 төгрөг, эцсийн үлдэгдэл 288,388,567.57 төгрөг (эхний үлдэгдэлээс сургууль хоорондын тооцооны-46,733,760.37 оюутны хөгжлийн зээлийн эрсдлийн 5%-196,564,563.70, эцсийн үлдэгдлээс сургууль хоорондын тооцооны - 30,791,710.37 оюутны хөгжлийн зээл, эрсдлийн 5% -257,596,857.20)
2. Үндсэн хөрөнгө анхны өртөгөөр 1,092,081,365.57 төгрөг, хуримтлагдсан элэгдэл 164,117,972.90 төгрөг, үндсэн хөрөнгийн үлдэгдэл өртөг 927,963,392.67 төгрөг (Засгийн газрын хувь оролцоо данс)
3. Өмнөх үеийн үр дүн данс 66,491,495.00 (Сургууль хооронд шилжүүлсэн хөрөнгө, өр төлбөр)

4. Бараа материал бэлтгэх урьдчилгаа, үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа, бусад урьдчилгаа, төсөл, гэрээт ажлын зардлын урьдчилгаа, бусад төлбөрийн урьдчилж орсон орлогын эхний үлдэгдэлээс 11,580,500.00 төгрөг, эцсийн үлдэгдэлээс 22,671,700.00 төгрөг (БАТС, ГУУС, ГХС, УТС, ХШУС, Захиргаа, Хэвлэлийн газар)
5. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн орлого, зардал сургууль хоорондын тооцооны 83,600,692,236.32 төгрөг, Хэвлэлийн газрын 105,109,910.00 төгрөг
6. Мөнгөн гүйлгээний тайлангийн орлого, зардал сургууль хоорондын 83,683,073,499.69 төгрөг, Хэвлэлийн газрын 164,031,160.00 төгрөг, БЗС-ийн санхүүжилт, кредит баталгаажуулалтын төлбөрийн 3,482,402,048.32

6.3 САНХҮҮ ТАЙЛАНГИЙН АУДИТИЙН ҮР ДҮН

ШУТИС-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн АХГ-2022/07/НА-СТА-ТӨА код бүхий аудитын тайланг Үндэсний аудитын газраас 2022 оны 3 дугаар сарын 15-ны өдөр хүлээлгэн өгсөн. Төрийн аудитын тухай хуулийн 6.3.1, 8.1, Төсвийн тухай хуулийн 8.9.8 заасны дагуу ШУТИС-ийн 2021 оны 12 сарын 31-ны өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлагналын аудит хийгдэж “Зөрчилгүй санал дүгнэлт” өгсөн.

Санхүү нягтлан бодох бүртгэлийн албанаас 2021 оны ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн санхүүгийн тайланг нэгтгэн Төсвийн тухай хуулийн 8.9.1-ийн дагуу 2022 оны 2 дугаар сарын 04-нд ҮАГ/АА2021-241 тоот гэрээ байгуулан ҮАГ болон Амгалан ахуй аудит ХХК-нд санхүүгийн тайлангаа хүргүүлсэн. Аудитын байгууллагаас НББОУС, СТОУС, УСНББОУС, АОУС, АДБОУС, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Аудитын тухай хуулийн хүрээнд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн байна. Дараах зөрчил дутагдал гарсан байна.

- Холбогдох хууль тогтоомж, журмын дагуу тендерийн сонгон шалгаруулалт явагддаггүй байх зөрчил буюу гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулаагүй, гэрээ дүгнэсэн актгүй 41.1 сая төгрөгийн урсгал засварын ажил гүйцэтгүүлсэн байна.
- Тайлант хугацаанд бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламжийг ня-бо бүртгэл, төсвийн гүйцэтгэлд бүрэн тусгаагүй нуун дарагдуулсан байх зөрчил буюу байр түрээслэх гэрээ байгуулаагүйгээр түрээсийн төлбөрт нийт 24 багш, ажилтнаас 31.3 сая төгрөгийн орлого санхүүгийн тайланд бүртгэсэн байна.
- Шилэн дансны мэдээллийг бүрэн байршуулаагүй, хугацаа хоцроосон байх зөрчил буюу харъяа бүрэлдэхүүн 21 сургуулиуд нь тайлант онд шилэн дансны цахим хуудсанд байршуулах 2351 мэдээллээс 16 мэдээлэл хугацаа хоцроосон. Үүнээс 5 сая төгрөгөөс дээш нийт 108,416.5 сая төгрөгийн мэдээ оруулахаас 25.9 сая төгрөгийн 4 мэдээг хоцроосон байна.
- Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллаагүй байх зөрчил буюу салбар сургуулийн ойн арга хэмжээний зардал 22.1 сая төгрөг, спортын уралдаан тэмцээний зардалд 13.6 сая төгрөг, албан конторын тавилга 105.4 сая төгрөг нийт 141.1 сая төгрөгийг зарцуулсан байна.
- Байгууллагаас авах нийт 22.7 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Тиймээс авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулах, аудитаар өгсөн зөвлөмжийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах.
- Гадаадад доктор хамгаалахаар явсан багшийн тусгаарлах байрны төлбөрт 2.4 сая төгрөг зарцуулсан байна. Төсвийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулж, хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллаж зөрчлийг давтан гаргахгүй байх